



МОНГОЛ УЛС  
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/278

Баруун-Урт сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын  
ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.5, 11.2.6, 19 дүгээр зүйлийн 19.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.7, аймгийн Засаг даргын 2022 оны А/13 дугаар захирамж, Үндэсний геологийн албаны даргын 2023 оны "Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай" Н-70 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар аймгийн Асгат сумын нутаг дэвсгэрт "Бор нуруу" нэртэй талбайд байрших

1.  $113^{\circ} 26' 14.07''$   $46^{\circ} 30' 55.47''$

2.  $113^{\circ} 26' 48.25''$   $46^{\circ} 30' 55.47''$

3.  $113^{\circ} 26' 48.25''$   $46^{\circ} 31' 21.09''$


4.  $113^{\circ} 26' 14.07''$   $46^{\circ} 31' 21.09''$  дугаар солбицол бүхий 59.46 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийг "Шарга" ХХК-д 15 жилийн хугацаатай олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг газрын мэдээллийн санд тусгаж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Төгөлдөр)-т даалгасугай.

3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайд явуулж буй үйл ажиллагаанд нь хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн хяналт шалгалтын тасаг (Г.Сугараа), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү), Асгат сумын Засаг дарга (Ц.Гансүх) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ